

БДБ-10 Багш

Албан ёсны мэдээлэл, Маягт БДБ-10.

Маягт БДБ-10-д ажиллавал зохих багш, ажиллаж байгаа багш, дутагдалтай багш, түүнчлэн цагаар хичээл зааж байгаа багшийн мэргэжил тус бүрээр гаргана. Тэдгээрийн боловсролын түвшин, насны бүлэг, мэргэжлийн зэрэг, багшилсан хугацааны мэдээллийг гаргана.

№	БДБ тайлангийн нэр		Тайлбар
1	БДБ-10	ЕБС-ийн багш нарын тайлан (нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн чиглэл)	Ажиллавал зохих багш, үндсэн багш, мэргэжлийн бус багш, шаардлагатай багш, цагийн багш, үндсэн багш нарийн боловсролын түвшин, нас, багшилсан хугацаа, мэргэжлийн зэрэг, мэргэжил дээшлүүлсэн байдал зэрэг мэдээлэл харагдана.
2	БДБ-10А	ЕБС-ийн үндсэн багш нарын тайлан (сургууль, хүйс, мэргэжлийн чиглэл)	Үндсэн багш нарийг мэргэжлийн чиглэлээр нь харуулна.
3	БДБ-10Б	ЕБС-ийн багш нарын тайлан (сургууль, нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн чиглэл)	Багш нарийн нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжлийн чиглэл, багшилсан хугацаа, мэргэжлийн зэрэг (зөвлөх, заах аргач, тэргүүлэх) гэх мэт мэдээллийг харуулна.

БДБ 10 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа:

1. Ажиллавал зохих багш -ийн дүнг **БДБ 10 тайланд** харуулахдаа энэ хичээлийн жилд ажиллаж байгаа багш дээр дутагдалтай багшийн тоог нэмж **Статистикийн удирдлага** -ын "**Байгууллагын асуулга**" үйл ажиллагааны **Багшийн мэдээлэл** хэсэгт бүртгэл хөтлөснөөр БДБ 10 тайлангийн ажиллавал зохих болон шаардлагатай багшийн тоо гарна.

2. Үндсэн багш-ийн тоо уг **БДБ 10 тайланд** орж ирээгүй тохиолдолд **Боловсролын удирдлага** -ын **Багш** үйл ажиллагаанд багш нарыг бүртгэж оруулахдаа **Төрөл** хэсэгт **бага ангийн үндсэн, дунд ангийн үндсэн, ахлах ангийн үндсэн** гэдэг сонголт хийсэн эсэхийг шалгана.

